**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**
**(Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагууд)**

**2026.01.06**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээний хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | |
| 14 | 31 | Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24 | 16.1.12. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр; (16.1.Улсын Их Хурал дараах тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэнэ:) | | | |
| 16 | 33 | Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29 | 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.) | ЭСҮТ-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, Багаж, техник хэрэгсэл худалдан авах, Лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, Харуул хамгаалалтын үйлчилгээ худалдан авах, Лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах (бүрхүүл шил наагч, сорох шүүгээ) 5 тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.<br>1/Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг урсгал төсөвт батлагдсан 693,080,500 сая төгрөгөөр 4 багцтай зохион байгуулсан.<br>2/2025 оны батлагдсан төсвийн хүрээнд багаж, техник хэрэгсэлд 27 сая төгрөг хуваарилагдсан ба нормын хувцас, зөөлөн эдлэлээс 34сая, урсгал засвараас 38 сая төгрөгийг тус тус шилжүүлж нийт 99 сая төгрөгөөр эмгэг судлалын лавлагаа лабораторит нэн шаардлагатай эдийн дамжлагын аппарат "Багаж, техник хэрэгсэл" худалдан авах тендерийг зохион байгуулсан.<br>3/Харуул хамгаалалтын үйлчилгээ худалдан авах тендерийг 20,520,000 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр зохион байгуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4/2024 оны давсан орлогоос 110 сая төгрөгийг үлдээж, Сангийн сайдын 2025.02.13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар хуваарилуулж эмгэг судлалын лабораторит нэн шаардлагатай эд, эсийн шинжилгээний слайд, кассет хадгалах шүүгээ худалдан авах “Лабораторийн тоног төхөөрөмж” тендерийг зохион байгуулсан.<br>5/Лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах (бүрхүүл шил наагч, сорох шүүгээ худалдан авах) тендерийг төсөвт өртөг 235,000,000 төгрөг 2025.09.09-30-ны хооронд амжилттай зохион байгууллаа.<br><br>Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулж, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу тендерийг нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулж, тендерийн зарлалыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудас болон Өглөөний сонинд нийтэлж, нээлттэй, ил тод байрлуулж, хэрэглэгчдийг тэгш мэдээллээр хангаж, тендер худалдан авалтыг төлөвлөгөөт хугацаанд амжилттай зохион байгуулсан. Хамгийн сайн тендерээр үнэлэгдэж шалгарсан оролцогчидтой гэрээ байгуулан, бараа бүтээгдэхүүн, багаж хэрэгслийн хангалт хийгдлээ. | | |
| 26 | 51 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34 | 7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | 1/2025оны 3-р сарын 27-нд “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийн хүрээнд орон даяар зохион байгуулагдсан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад Эмгэг судлалын үндэсний төвийн ажилтнууд идэвх санаачлагатай хамрагдан оролцлоо.<br><br>2/Төвийн нийт ажилтнуудын цахим хуудсанд 3 дугаар сарын 26-ны өдөр газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах мэдлэг олгох зорилгоор доорх линкийг байршуулсан.<br> Газар хөдөлтийн өмнө https://belenbai.mn/before-earthquake<br> Газар хөдлөлтийн үед https://belenbai.mn/during-earthquake<br> Газар хөдлөлтийн дараа https://belenbai.mn/after-earthquake<br> Гамшгийн үед бэлдэх зүйлс https://www.youtube.com/watch?v=pc7xSYAShPs | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ажилтнууд дээрх мэдээлэлтэй уншиж танилцсанаар сургуулилтын зарлан мэдээллийн дохиогоор ажиллахад авах арга хэмжээний талаарх мэдлэгээ сэргээсэн.<br><br>3/ЭМЯ-с “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ” сэдэвт дадлага, сургуулилтыг 2025 оны 05 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд "Гамшгийн орон тооны бус ажилтан" болон ХАБЭА-ууд хамрагдсан. | | |
| | 52 | | 8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх. | Төвийн захирлын 2025 оны А/10 тоот тушаалаар “Гамшгаас хамгаалах орон тооны бус ажилтан”-ыг томилсон, бөгөөд ЭСҮТ-ийн гамшгийн хамгаалах төлөвлөгөө, гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч, мэргэжлийн ангийн бүтцэд тодотгол хийж, аврах багаж, тоног төхөөрөмж,техник, хамгаалах хэрэгсэлийн нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллалаа.<br>Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж энэ талаарх мэдээллээ 2025.10.07-ны өдрийн 355 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 28 | 54 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай 2020-12-03 Дугаар 2020 №36 | 1.2/. Иргэдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулж удирдлагаар хангахыг Эрүүл мэндийн сайдад үүрэг болгох; | Хамааралгүй | | |
| | 60 | | 1.2/. Монгол хүний удмын санг цус ойртолт, удамшлын өвчлөлөөс сэргийлэх зорилгоор "Угийн бичиг"-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 онд багтаан хэрэгжүүлэх, | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлагатай бол холбогдох судалгаанд тулгуурлан ургийн овгийн нэршлийг шинэчлэх арга хэмжээг зохион байгуулах; | | | |
| | 62 | | 1.4/. Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт технологи бүхий генетикийн лаборатори, генийн сан байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх, шаардагдах төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэх; | Хамааралгүй | | |
| | 64 | | 1.6/. Монгол Улсын хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах асуудлыг хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх; | 1/Нийслэл болон аймаг орон нутгийн эмгэг судлалын нэгжид орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан. Энэхүү жагсаалтыг хавсарган, тоног төхөөрөмжийн хангалт хийх албан хүсэлтийг 2025.03.13-ны өдрийн 88 тоот албан бичиг, 2025.04.14-ний өдрийн 145 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газарт хүргүүлсэн.<br>2/2024 оны 12 дугаар сард Увс АНЭ-ийн эмгэг судлалын тасагт 446 сая төгрөг, Орхон БОЭТ-ийн эмгэг судлалын тасагт 773 сая төгрөгийн санхүүжилтийг ЭМЯ-аас тусгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэгдсэн бөгөөд тоног төхөөрөмж 2025 оны 06 дугаар сард нийлүүлэгдсэн. Үүнд слайд сканер болон бусад иж бүрэн тоног төхөөрөмж багтсан бөгөөд орон нутгийн иргэд эд, эсийн эмгэг судлалын шинжилгээг УБ хотод авч ирж шинжлүүлэх урсгалыг багасгаж, төвлөрлийг саруулла.<br>3/Өмнөговь, Өвөрхангай, Дорнод БОЭТ, Хэнтий, Завхан, Хөвсгөл АНЭ-ийн эмгэг судлалын тасаг, Эмгэг судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвийн эмгэг судлалын тасгийн лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмжүүд шийдвэрлэх зорилгоор 2025.04.30-ны өдөр ЭМЯ, Төрийн худалдан авах ажиллагааны газраас 11 тэрбум 43 сая төгрөгийн тендерийг зарласан боловч төсвийн хэмнэлтийн хуулиар 2025.06.01-д эргэн татагдсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4/Эрүүл мэндийн сайдын төвлөрөл сааруулах ажлын багт ЭСҮТ-ийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Б.Ганзориг орж ажилласан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Ховд БОЭТ, 2025 оны 01 дүгээр сарын 08-ны Говь-Алтай АНЭ, 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр Баянхонгор АНЭ, 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Өвөрхангай БОЭТ, 2025 оны 02 дугаар сарын 04-ний Увс АНЭ, 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Завхан АНЭ, 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Тосонцэнгэл СНЭ, 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Хөвсгөл АНЭ, 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Булган АНЭ, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Багануур ДЭМТ тус тус томилогдон ажиллалаа. | | |
| | 67 | | 6.б/. Нийгмийн сүлжээний хяналтгүй хэрэглээнээс шалтгаалан цахим гадуурхалтад өртөх, хүүхэд дэлгэцийн хамааралтай болох, цахим гэмт хэргийн хохирогч болох, нас, сэтгэхүйн онцлогт үл тохирох, зүй бус агуулгатай контент үзэх, зан суртахуунд нь сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:) | Хамааралгүй | | |
| | 68 | | 6.в/. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудалтай холбоотой сэтгэцийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар зорилтот хөтөлбөр боловсруулах. (6/Эмнэлгийн | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:) | | | |
| | 71 | | 1.9. Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг 2025 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах; | 1/ЭМДҮЗ-с эмгэг судлалын тусламж, үйлчилгээг даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг хийсэн ба үүний дагуу төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг гүйцэтгэлээр санхүүжилт авдаг боллоо. (ЭМДҮЗ-ийн 2024 оны 6 дугаар тогтоол 2025 оны 1-р сарын 23-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан. ЭСҮТ-тэй холбоотой заалтууд хэвээр батлагдсан. ЭМДЕГ-ын даргын 2024.11.15-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” А/150 дугаар тушаалаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эмгэг судлалын шинжилгээний 10 нэр төрөл батлагдсан.)<br>2/ЭСҮТөв ЭМДЕГ-тай гэрээ байгуулах хүсэлтийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр 110 тоот албан бичгээр, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 162 тоот албан бичгээр, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 197 тоот албан бичгээр нийт 3 удаа хүргүүллээ.<br>-ЭМДЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын даргын 2024.11.04-ний “Тогтоол хүргүүлэх тухай” 04/4000 албан бичиг, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын 2024.12.10-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 5/5196 албан бичгээр Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээлэх, цахим системийг хөгжүүлэлт хийж хамтран ажиллахыг үүрэг болгосон.<br>-ЭСҮТ-ийн 2025.03.17-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 110 дугаар албан бичгийн хариу ЭМДЕГ-ийн Худалдан авалт, гэрээлэлтийн газрын 2025.03.31-ний өдөр 05/762 дугаартай албан бичгээр “ЭМД-ийн тухай хуулийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах ба ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолд 3 жилд нэг удаа нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна гэсний дагуу 2025 оны 03 дугаар улиралд багтаан сонгон шалгаруулалт зохион байгуулагдана” гэдгийг мэдэгдсэн.<br>-ЭСҮТ-ийн 2025.05.02-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх” 162 дугаар албан бичгээр ЭМДЕГ-т хүсэлт хүргүүлсэн. Дээрх хүсэлт хүргүүлэх албан бичигт гэрээлэлтэд тусгагдах эмгэг судлалын шинжилгээний нэр төрөл, too хэмжээ, ЭМС-ын 2022 оны А/216, Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 49/А/118 | - | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тушаалын хуулбар, ЭСҮТ-с үзүүлдэг тусламж үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах санал, ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/150 дугаар тушаалыг тус тус хавсарган хүргүүлсэн. | | |
| 33 | 72 | НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-19 Дугаар 2023 №08 | 3/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх; | Хамааралгүй | | |
| 34 | 73 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухаи 2023-05-04 Дугаар 2023 №35 | 3а/. ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | - Японы засгийн газрын Жайка олон улсын байгууллага-ын SATREPS төсөлд “HDV вирусын халварын хяналтыг сайжруулах” төслийн хүрээнд хамтран ажиллах төлөвлөгөө гарсан бөгөөд төсөл 2026 оны 4-р сараас эхлэхээр төлөвлөгдсөн.<br>- Уушгины жижиг эсийн өмөнгийн судалгааны чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор БНХАУ-ын Swan X Limited болон Hainan Jeiyatai Consulting компаниудтай 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. | 100% | |
| | 74 | | 3в/. ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх. | Ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Эрүүл, идэвхтэй насжилт” сэдвийн хүрээнд нэг сарын аян зохион байгуулан ажиллаа. Тус аяны хүрээнд “Ахмад настны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор төвийн захирлын 2025 оны А/57 тоот тушаалаар ахмадын сан байгуулан, ажиллуулах журмын хамтаар албажуулан баталсан.<br>“Эрүүл, идэвхтэй насжилт” аяны хүрээнд:<br>1/2025.10.02-ны өдөр ЭСҮТ ахмад ажилтнуудаа хүндэтгэл үзүүлэн, 21 ахмад ажилтнаа хүлээн авсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2/2025.10.15-ны өдөр АУ-ны доктор, дэд профессор, зөвлөх зэргийн эмч Ш.Энхтуяаг урьж хүндэтгэлийн лекц зохион байгуулж, анатомийн эмгэг судлаач эмчийн үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдаж буй 16 резидент эмч хамрагдсан.<br>3/2025.10.22-ны өдөр “Ахмадаа сонсъё” чөлөөт уулзалт ярилцлага зохион байгуулж, 39 эмч, резидент эмч нар хамрагдан оролцлоо. | | |
| 35 | 75 | ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2023-05-04<br>Дугаар 2023_32 | 1.3. төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх. | 1/Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2023 оны 16 дугаар тогтоолоор томилогдсон ЭСҮТ-ийн ёс зүйн салбар хороо нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Ёс зүйн салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаа.<br>Ёс зүйн чиглэлээр 2025 онд 6 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 242 ажилтан хамрагдсан. Үүнд:<br>1. Медскан төвийн гүйцэтгэх захирал, хавдар судлаач эмч Б.Бат-Эрдэнийн 2025.01.22-ны өдрийн “Ажлын байрны стресс, менежемент” сэдэвт сургалтад 33 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>2. Полиси төвийн лектор Г.Эрдэнэгэрэлийн 2025.03.26-ны өдрийн “Аз жаргалтай ажлын байр” сэдэвт сургалтад 29 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>3. Анагаах ухааны доктор, дэд профессор Ч.Батнайрамдал багшийн 2025.06.30-ны өдрийн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тулгуур зарчим” сэдэвт сургалтад 41 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>4. Мэргэн түшээ сургалтын төвийн сургагч багш Ч.Отгончулуунаас 2025.08.18, 28-ны өдөр “Байгууллагын соёл” сэдвээр сургалт авч, нийт 33 ажилтан оролцлоо.<br>5. Аддиктологийн төвийн эмч О.Баатаржав “Ажлын байрны стресс менежмент” сэдвээр 2025.11.24-ний өдөр 61 ажилтан хамрагдсан.<br>6. ЭМЯ-ны Ерөнхий мэргэжилтэн, Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, АУ-ны доктор, профессор Э.Баярмаа “Байгууллагын соёл” сэдэвт ёс зүйн лекцэнд 45 ажилтан хамрагдсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2/ЭСҮТ-д Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол 2025 онд ирээгүй бөгөөд тус төв нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ёс зүйн чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг явуулж байна.<br>3/Эрүүл мэндийн салбарын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Ёс зүйн зөрчлийг тэвчих сэтгэлгээг хэвшүүлье" 2 сарын аяны хүрээнд удирамж, төлөвлөгөө боловсруулан төвийн захирлын 2025 оны А/74 тоот тушаалаар зохион байгуулах комисс томилогдон ажиллалаа.<br>"Ёс зүйн зөрчлийг тэвчих сэтгэлгээг хэвшүүлье" аяны хүрээнд төвийн нийт ажилтнуудыг 8-н багт хуваан, 6 төрлийн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг 2025.12.19-ны өдөр үнэллээ. | | |
| 36 | 76 | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59 | 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай. | 1/ЭСҮТ-ийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг төвийн захирлаар 2025.03.14-ний өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br>2/Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2025.12.12-ны өдөр ЭМЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын хуулийн мэргэжилтэнд хүргүүллээ.<br>3/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн албан шинээр томилогдох 7 ажилтны ХАСУМ-ыг хянуулж, АТГ-с ирсэн албан бичгийг үндэслэн 6 ажилтны албан тушаалд шинээр томилж ХАСХОМ-ыг баталгаажуулан ажиллалаа.<br>4/2025.02.15-ны дотор хуулийн хугацаанд багтаан 11 ажилтны ХАСХОМ-ийн мэдүүлгийг хуулийн хугацаанд баталгаажуулан Авлигатай тэмцэх газарт илгээн хянуулж баталгаажуулсан. | 100% | |
| 37 | 77 | МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА | 1.7.Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүс нутгийн онцлогийг харгалзан ялгаатай хуваарилах, иргэдийг тусламж үйлчилгээний шатлал хооронд хүнд суртал, чирэгдэлгүйгээр шуурхай шилжүүлдэг байх зэрэг | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93 | зохицуулалтын оновчтой арга хэрэгслийг 2023 онд багтаан шийдвэрлэж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх; | | | |
| | 78 | | 1.8.Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог үргэлжлүүлэн эрчимжүүлж, хөдөөгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах; | 1/Ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг “Бриллиант” эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, шинжилгээний 4 багцаас ажилтнуудын санал авч үзлэг оношилгоонд хамруулан ажиллалаа. Тус үзлэг шинжилгээг 2025 оны 10 дугаар сарын 15-28-ны хооронд зохион байгуулж, үндсэн орон тоонд ажиллаж буй 47 ажилтныг 100% бүрэн хамрууллаа.<br>2/Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын хүрээнд төвийн нийт 64 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, резидент эмч нараас судалгаа авахад 11 ажилтан урьд нь өвчилж байсан, 38 ажилтан сүүлийн 5 жилийн дархлаажуулалтад хамрагдсан нь тогтоогдсон. Сайн дурын үндсэн дээр 2025 оны 10 дугаар сарын байдлаар 7 ажилтны Улаанбурхан өвчнй эсрэг дархлаажуулалтад хамрууллаа.<br>3/Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 сарын 11-ний Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай А/334 дугаар тушаалын дагуу ХӨСҮТ-өөс 50 хүн тун вакцин хүлээн авч ажилтнуудыг 100% дархлаажуулалтад хамрууллаа.<br>4/Ажилтнуудыг гепатит B, C, ХДХВ, тэмбүүгийн шинжилгээнд хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, 37 ажилтан гепатит B, C-ийн шинжилгээ өгснөөс 1 ажилтан гепатит C вирус сул эерэг, 36 ажилтан сул эсэрэг гарсан. Эдгээр 37 ажилтнаас 18 нь ДОХ, тэмбүүгийн шижилгээнд хамрагдаж бүгд сөрөг гарсан. 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдөр гепатит B, C шинжилгээ өгч сөрөг гарсан ажилтнууд Anti-HBs (гепатит B-ийн дархлал) тодорхойлох шинжилгээг ХӨСҮТ-д өгсөн. Үүний үр дүнд дархлаа дунд болон дархлаа тогтоогүй 17 ажилтныг 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр гепатит B-ийн дархлаажуулалтад бүрэн хамрууллаа.<br>4/"Бүрэн мед" эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний үндсэн дээр эмэгтэй ажилтан болон резидент эмч нарыг хамруулан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нийт 50 ажилтныг умайн хүзүүний эсийн шинжилгээ болон эмэгтэйчүүдийн үзлэг шинжилгээнд хамруулла. 5/Уромед эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний үндсэн дээр тархины судасны дуплекс ЭХО оношилгоонд 2025 оны 12 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд 10 ажилтныг хамруулла. 6/Нийслэлийн шүд эрүү нүүрний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ажилтнууд болон тэдний хүүхдүүдийн дунд шүдний үзлэг хийх ажлыг зохион байгууллаа. Үзлэгт 9 ажилтан, 6 хүүхэд хамрагдсан бөгөөд шүдний эмчилгээ үйлчилгээ шаардлагатай хүүхдүүдийг 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн эмчлүүлж, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. | | |
| | 79 | | 1.10.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах; | 1/ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтаар 2024 оны 12-р сард нийлүүлэгдсэн 835,129,362.3төг (Найман гучин таван сая нэг зуун хорин есөн мянга гурван зуун жаран хоёр) үнэ бүхий 7 нэр төрлийн 7 тоног төхөөрөмжийн орлогод авах тухай ЭМСайдын 2025.04.28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар албажиж ирсэн. Үүний дагуу НББ-д тусгаж, ТӨБЗГ-ын цахим системд үндсэн хөрөнгөд бүртгэсэн.<br>2/ Эрүүл мэндийн сайдын 2025.04.28-ны өдрийн "Тоног төхөөрөмж орлогод авч, хуваарилах тухай" А/167 дугаар тушаал гарсантай холбогдуулан дээрх лабораторийн тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ОУ-ын стандартын дагуу үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэж, ашиглалтад оруулсан. Үүнд:<br>- Эд боловсруулах процессор - 1ш*147,449,741.2төг (Пролианс ХХК)<br>- Парафин цутгагч аппарат-1ш*55,435,078.2төг (Пролианс ХХК)<br>- Эргэлтэт микротом-1ш*62,295,551.9төг (Пролианс ХХК)<br>- Будагч автомат аппарат-1ш*219,459,493.3төг<br>- Эд эс хуулагч/grossing wells-1ш*44,578,666.7төг (Пролианс ХХК)<br>- Ухаалаг слайд дугаарлагч принтер-1ш*95,956,552.9төг (Медмонгол ХХК) | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | - Ухаалаг кассет дугаарлагч принтер-1ш*209,954,278.1төг (Медмонгол ХХК)<br>3/2025 оны 4 дүгээр сарын 24-ээс 12 дугаар сарын 31-г хүртэл нийт 21 нэр төрлийн, 50 ширхэг 1,040,087,812.25төг үнэ бүхий тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдлээ. Үүнээс:<br>-6 нэр төрөл, 14 ширхэг тоног төхөөрөмж худалдаж авсан.<br>-ЭСҮТ-н тендерээр нийт 5 нэр төрлийн 27 ширхэг тоног төхөөрөмжийг худалдаж авсан. Үүнд:<br>2024 оны давсан орлогоос үлдээж, 2025 онд ЭСҮТ тендер зарласан:<br>• Эд, эсийн шинжилгээний слайд хадгалах шүүгээ-10ш<br>• Кассет хадгалах шүүгээ-14ш<br>• Эдийн дамжлагын аппарат-1ш<br><br>2025 оны давсан орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж ЭМЯ-аас зөвшөөрсөн тул 09.09-нд тендер зарласан.<br>• Бүрхүүл шил наагч автомат аппарат-1ш (190,000,000төг)<br>• Сорох шүүгээ-1ш (45,000,000төг) | | |
| 38 | 80 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ | 1.4.Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг МҮОНРТ, Боловсрол суваг болон бусад радио, телевиз, сонин хэвлэл, нийгмийн сүлжээг ашиглан хүн амын дунд зохион байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх; | Хамааралгүй | | |
| 40 | 83 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017-07-05 | 1.7.Цэцэрлэгийн хүүхдийн хоолны стандартыг мөрдүүлж, | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2017 №25 НББСШУБХ | эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах; | | | |
| 41 | 85 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.5.Эрүүл мэндийн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, ажиллах. | Хамааралгүй | | |
| 43 | 87 | Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-12-20 Дугаар 2018 №24 НББСШУБХ | 1.12.Агаарын болон орчны бохирдлоос хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар боломжит бүх арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлэх; | Хамааралгүй | | |
| 44 | 88 | Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019-10-22 Дугаар 2019 №08 НББСШУБХ | 2.Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 2.6.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 141.6-д заасны дагуу Үндэсний зөвлөлийн гишүүний ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоож, олгоно. | | | |
| 47 | 91 | Чиглэл өгөх тухай 2021-06-15 Дугаар 2021 №01 ИЦББХ | 1. Монгол Улсын Их Хурлын Инноваци цахим бодлогын байнгын хорооны 2020 оны 02 дугаар тогтоолоор байгуулсан Ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/ Эрүүл мэндийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний хөрөнгө оруулалтын үр ашгийг судалж, төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах | Гүрэн Софт ХХК Ай-Хоспитал программ хөгжүүлэлт хийгдэж, амьд сорьцын шинжилгээн дээр бүрэн хийгдэж амьд сорьцын шинжилгээний хуучин хэрэглэгдэж байсан цаасан бүртгэлийг сольж 100% цахим системд шилжлээ. Эмгэг судлалын задлан шинжилгээний протокол сайжруулалт хийгдэж байна.<br><br>Ингэснээр эмнэлгүүд шинжилгээний хариуг цаасан хэлбэрээр тээвэрлэх, бичиг хэргийн зардлыг багасгах нөхцөл бүрдлээ. | 100% | |
| | 92 | | 2. Эрүүл мэндийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт мэдээллийн технологийн аудитыг төрийн аудитын байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | - | | |
| | 93 | | 3. Иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Цахим эрүүл мэнд" төслийг эрчимжүүлж эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн системийг цахим үйлчилгээний нэгдсэн систем /Е-МОНӨОША/-Д холбох асуудлыг судалж, хологдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | I-Hospital программыг бусад эмнэлгүүдийн программд интеграци болох, мэдээллийг саадгүй шилжүүлдэг болох хүсэлтийг ЭМЯ-ны Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтэст 2025.06.04-ний өдрийн 203 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 48 | 96 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-10-19 Дугаар 2021 №05 | 2.Эрүүл мэндийн даатгалын санд төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг оновчтой болгох, төлөвлөлтийг сайжруулах, санг болзошгүй эрсдэлээс хамгаалах; | Хамааралгүй | | |
| | 97 | | 3.Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь баталдаг байх, одоо мөрдөгдөж буй тушаал, шийдвэрийн зөрчлийг арилгах; | | | |
| | 98 | | 7. Хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн засаглалыг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлүүдийг байгуулах ажлыг 2021 оны 12 дугаар сард багтаан дуусгах, Багануур, Баянгол, Налайх, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг нэгдсэн эмнэлэг болгож, хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх боломжийг бүрдүүлэх | Хамааралгүй | | |
| | 101 | | 14.Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа программ хангамжуудыг нэгтгэж, нэн даруй нэгдсэн мэдээлэл солилцооны | “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэж байгаа байдалд судалгаа, шинжилгээ хийж санал, дүгнэлт боловсруулах” үүрэг даалгавар бүхий ажлын хэсгийн 20 дугаар хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Эмгэг судлалын үндэсний төвд ашиглагдаж буй I-Hospital цахим системийг https://system.gov.mn/ цахим системд оруулсан. Энэ талаарх | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | платформд шилжүүлэх, цахим хяналтыг сайжруулах | мэдээллээ 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ЭМЯ-нд албан бичгээр хариу хүргүүлсэн. | | |
| | 102 | | 15.Эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулах, ил тод нээлттэй байдлыг хангах, хяналтыг сайжруулах | ЭСҮТ-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, Багаж хэрэгсэл худалдан авах, Лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, Харуул хамгаалалтын үйлчилгээ худалдан авах, Лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах (бүрхүүл шил наагч, сорох шүүгээ) 5 тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.<br>Дээрх 5 удаагийн тендер худалдан авалтыг зохион байгуулах үнэлгээний хороод төвийн захирлын тушаалаар байгуулагдаж, тендер худалдан авалтыг www.tender.gov.mn цахим хуудаст нийтэлж, нээлттэй, ил тод байрлуулж, оролцогчдыг тэгш мэдээллээр хангаж ажилласан. | 100% | |
| 50 | 105 | Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022 №06 БСШУСБХ | 1.1. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хамгаалах арга хэмжээ авах; | Хамааралгүй | | |
| | 108 | | 1.4. хүүхдэд үйлчилдэг болон хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байгууллагыг тамхигүй орчин болгох, дам тамхидалтаас сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Хамааралгүй | | |
| 51 | 110 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.10. Ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг (оношлогоо, эмчилгээний нэр төрөл, өрөө тасалгааны тоо хүртээмж, | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэшсэн эмч, мэргэжилтний тоо) нэмэгдүүлэх; | | | |
| 52 | 112 | Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ | 1.4. Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх, боловсруулах, үйлдвэрлэх, борлуулахад тээвэрлэхэд онцгой анхаарч, нийслэл орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон төсөвт байгууллагуудыг тохирлын баталгаатай, эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах, үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалт, даатгалын сангийн зарцуулалтаар дэмжих ажлыг зохион байгуулах; | Хамааралгүй | | |
| 53 | 113 | Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022.06.15 №18 НББХ | 1.1.Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, анагаах ухааны дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр эмнэлгүүдийг хангах замаар Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчлэх боломжийг бүрдүүлэх; | 1/Молекул генетикийн FISH шинжилгээний аргыг 2025 оны 6 сараас эхлэн Монгол улсын эмгэг судлалын салбарт анх удаа 14 нэр төрлийн пробоор нэвтрүүллээ. Үүнд:<br>- CDKN2A (9p21.3) Orange 9q21.11 Green<br>- IGH (14q32) Break Apart Orange/Green<br>- ALK/EML del-TECT™ Four Color<br>- TP53 (17p13) Orange+Copy Control 17 Green<br>- MYC (8q24) Orange + Copy Control 8 Green<br>- MET (7q31) Orange + Copy Control 7 Green<br>- MDM2 (12q15) Red + Copy Control 12 Green<br>- HER2<br>- BRAF (7q34)<br>- BRAF (7q34)<br>- ALK<br>- ROS1<br>- PDL1(9p24)/CSP9<br>- PDL1(9p24)/<br>- CLL<br>- 7p EGFR зэрэг 14 проб ашиглан 45 хүний 52 сорьцод шинжилгээ хийж үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна.<br>2/Хорт хавдрын эмгэг судлалын оношилгоонд хорт хавдрын эсээс ялгардаг уургаар оношилдог иммуногистохимийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээний нэр төрлийг 30-аар нэмэгдүүлж, нийт 101 нэр төрлийн иммуногистохимийн эсрэгбиеэр оношилгоо хийлээ. | | |
| | 117 | | 1.5.Иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах | Хамааралгүй | | |
| | 122 | | 1.1.4. Асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах; | Хамааралгүй | | |
| | 125 | | 1.1.6/. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр сэтгэцийн хурц эмгэг өөрчлөлттэй хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нь тогтоогдохгүй байгаа, хагас, бүтэн өнчин хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бүтэц, орон тоог нэмэгдүүлэх; | Хамааралгүй | | |
| | 127 | | 3а/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй | Эмгэг судлалын үндэсний төвд өнгөрөгч 2025 онд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээ байхгүй. | - | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах; | | | |
| | 128 | | 6г/.төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах. | ЭСҮТ нь жил бүрийн төсвийн төслөө боловсруулан, Эрүүл мэндийн яамны Санхүү эдийн засгийн бодлогын газарт саналаа хүргүүлэн ажилладаг. 2026 оны төсвийн төслөө боловсруулан тооцоолол хийж 2025 оны 06 дугаар сард Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 58 | 131 | Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10 | 1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх; | Хамааралгүй | | |
| | 133 | | 1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх; | Хамааралгүй | | |
| 59 | 134 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх | 1/Эйблсофт ХХК-тай 2025.04.25-ны өдөр АҮШ-25/12 гэрээг байгуулж Able программыг 1,940,000 төгрөгөөр худалдан авч, өдөр тутмын албан хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд албан бичгийг үндэсний бичгээр хөтлөх үйл ажиллагааг 2025 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүллээ.<br>2/ЭСҮТ- нь өөрийн байрандаа крилл бичгээр байгууллагын албан ёсны хаягжилтыг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Модун дизайн ХХК-р гүйцэтгүүлж хийлгэсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | | | |
| 60 | 135 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60 | 8. Хар тамхи, мансууруулах бодисоор өсвөр, залуу үеийг хордуулж байгаа нөхцөл байдлыг судлан, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тусгах | Хамааралгүй | | |
| 61 | 136 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.12. Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болсны үндсэн дээр хүн амд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Нэгдсэн мэдээллийн сан бий болгох талаар хийсэн ажлууд, түүний үр дүнд сэтгэл зүйн ямар тусламж үйлчилгээг үзүүлсэн, гарсан үр дүнг тусгах | Хамааралгүй | | |
| | 137 | | 1.13. Иргэдийн нас баралтад нөлөөлж байгаа өвчин эмгэгийн байдалд судалгаа хийж, | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | өвчлөлийг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, санхүүжилтийг шийдвэрлэх. | | | |
| | 138 | | 1.14.Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг чангатгах. | Хамааралгүй | | |
| | 139 | | 1.17.Хүний эрүүл мэндэд нөлөөтэй эмийн бус бүтээгдэхүүн /чихэр, давс, хансан тос ихээр агуулсан хүнс, зохицуулах үйлчилгээний хүнс, биологийн идэвхт бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, тамхи/ -ийн тусгай зөвшөөрөл, бүртгэл, сав, баглаа боодол, шошгын танилцуулга, зар сурталчилгааг зохицуулах, хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох. | Хамааралгүй | | |
| 62 | 140 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2.Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Засгийн газрын тэрбум мод үндэсний хөтөлбөрт Эмгэг судлалын төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон бөгөөд мод тарих арга хэмжээнд оролцож, хавсрын тариалалдтад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, намрын тариалалтад 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр тус тус оролцож, “Олон Улсын эко цэцэрлэгт хүрээлэн”-ийн төслийн талбайд хаврын тариалалтад оролцсон. | 100% | |
| 63 | 141 | Халдварт өвчний өнөөгийн байдал, хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2010-03-19 Дугаар 2010_11/06 | 1."Дархлаажуулалтын тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай", "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, вакцины нийлүүлэлт, эм, хүнсний зохицуулалтын бие даасан алба байгуулах, хөндлөнгийн хяналтыг тодорхой | ТХААГазрын ерөнхий гэрээнд эмнэлгийн 1 удаагийн хэрэгсэл багтсан байдаг тул цахим дэлгүүрээр дамжуулан худалдан авалтыг зохион байгуулж ажилладаг. 2025 онд нийт 37,311,500 төгрөгөөр эмнэлгийн 1 удаагийн хэрэгсэл худалдан авч лабораторийн үйл ажиллагаанд зарцуулсан. Үүнд:<br>1/2025.05.16-ны өдрийн ЭСҮТ/020/001 дугаартай гэрээгээр 7,797,000 төгрөгийн 1 удаагийн халад 900ш, 1 удаагийн малгай 900ш, амны хаалт 900ш, улавч 300ш | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | болгох, зарим эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин тоног төхөөрөмжийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрээс шууд худалдан авах бололцоог бүрдүүлэх, улсын хэмжээнд вакцин, биобэлдмэлийн хөндлөнгийн хяналтын лаборатори байгуулах, төрийн хяналтыг чангатгах, хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх, | 2/2025.10.03-ны өдөр ЭСҮТ/021/001 дугаартай гэрээгээр 9,592,500 төгрөгийн 1 удаагийн халад 1000ш, 1 удаагийн улавч 1000ш, 1 удаагийн амны хаалт 1300ш<br>3/2025.10.09-ны өдөр ЭСҮТ/023/001 дугаартай гэрээгээр 250,000 төгрөгийн 1 удаагийн малгай 1000ш<br>4/2025.12.19-ний ЭСҮТ/024/001 дугаартай гэрээгээр 572,000 төгрөгийн 1 удаагийн амны хаалт 2600ш<br>5/2025.12.23-ны өдөр ЭСҮТ/025/001 дугаартай гэрээгээр 19,100,000 төгрөгийн 1 удаагийн халад 1 удаагийн улавч, 1 удаагийн малгайг тус бүр 2000ш<br><br>Улаанбурхан өвчний дархлаажуулалтад 7 ажилтныг, гепатит В вирусын дархлаажуулалтад 17 ажилтныг, томуугийн дархлаажуулалтад 50 ажилтныг тус тус хамруулж, нийт ажилтнуудын дунд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. | | |
| | 142 | | 2.Биотехнологийн цогцолбортой болох, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн биотехнологи, иммуноглобулины үйлдвэрлэлийг дэмжих, товлолын бус вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байгаа улсын байгууллага болон хувийн аж ахуйн нэгжийг төрийн зүгээс анхаарч, хууль, эрх зүйн хувьд дэмжин, хамтран ажиллах, | Хамааралгүй | | |
| 64 | 143 | Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 2011_25/24 | 1. Био-аюулгүй байдлыг хангах урт хугацааны цогц бодлого бүхий үндэсний хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх | Хамааралгүй | | |
| | 144 | | 4. Био-аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилготой биоаюулгүй ажиллагааны гуравдугаар зэрэглэлийн лаборатори байгуулах | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлэх | | | |
| | 145 | | 6. Молекул биологи, био-анагаах, биотехнологи, нано технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох | Хамааралгүй | | |
| | 146 | | 2. Био-аюулгүй байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр ажилладаг төрийн захиргааны болон судалгаа шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлэх, | Хамааралгүй | | |
| | 147 | | 5. Хувиргасан амьд организмтай холбоотой шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүх нийтийн боловсрол, мэдлэг олгох сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, | Хамааралгүй | | |
| 65 | 148 | Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц - чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналт 2013-01-08 Дугаар 2013_03/03 | 2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох; | Хамааралгүй | | |
| | 149 | | 3. Бүсийн төвүүдэд болон эм, эмнэлэгийн хэрэгсэл нэвтрүүлдэг хилийн боомтууд дээр эм, биобэлдмэлийн сорилын лаборатори байгуулах, шинжилгээний түргэвчилсэн арга нэвтрүүлж, хил гаалийн хяналтыг сайжруулах; | Хамааралгүй | | |
| | 150 | | 4. Цус сэлбэлт судлалын шинэ төвийн барилгыг шаардлагын хэмжээнд барих хэмжээний хөрөнгө /2,9 тэрбум төгрөг/ болон гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх; | | | |
| | 151 | | 6.Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох, эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглох | Хамааралгүй | | |
| 66 | 152 | Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2014-10-20 Дугаар 2014_52/30 | 2.8.Агаарын бохирдлоос үүдэлтэй иргэний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөлөл болон өвчлөлийг бууруулах цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх | Хамааралгүй | | |
| 67 | 153 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээррийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргсан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | Хамааралгүй | | |
| | 154 | | 1.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, донтогчдын талаарх судалгааг гаргах, тэдний албандан эмчлэх эмчилгээний арга зүй, стандартыг тогтоож, мэргэшсэн эмч, сэтгэл зүйч бүхий наръологийн төвийг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх. | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 68 | 155 | Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01 | 3.10.Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах | Хамааралгүй | | |
| 69 | 156 | Цар тахлын эсрэг биобэлдмэл, вакцин үйлдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай 2021-05-12 Дугаар 2021_144 | 3. Цаашид гарч болзошгүй цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв”-ийн дэргэд Коронавирусын эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины үйлдвэр, Вакцины хяналтын үндэсний лаборатори байгуулах тооцоо, судалгаа хийж, Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | Хамааралгүй | | |
| 70 | 157 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн | Эйблсофт ХХК-тай 2025.04.25-ны өдөр АҮШ-25/12 гэрээг байгуулж Able программыг 1,940,000 төгрөгөөр худалдан авч, өдөр тутмын албан хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хос бичгээр хөтлөх үйл ажиллагааг 2025 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр батлаж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | |
| 71 | 158 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | Эмгэг судлалын үндэсний төв нь улсын хэмжээнд эмгэг судлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх тусгай мэргэжлийн төв бөгөөд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах нийтлэг ажил, үйлчилгээнээс харуул хамгаалалтын үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн ажиллалаа.<br>Энэ хүрээнд 2025 оны худалдан авалтын төлөвлөгөөнд 20,520,000 төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын харуул хамгаалалтын тендерийг 2025 оны 03 дугаар сарын 10-20-ны хугацаанд зарлаж, ганц оролцогч материал ирүүлсэн. Материалыг хянан үзэж, шаардлага хангасан тул “Өлзий Хишиг Гранд” ХХК шалгаран, гэрээ байгуулан ажиллалаа. | 100% | |
| | 159 | | 3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | | | |
| 72 | 160 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | Хамааралгүй | | |
| 74 | 162 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга | Вамедын төсөл, ЭМСайдын 2025.04.28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтаар 835,129,362.3 төгрөгийн (Найман гучин таван сая нэг зуун хорин есөн мянга гурван зуун жаран хоёр) үнэ бүхий тоног төхөөрөмж нийлүүлэгдлсэн. Үүнд:<br>- Эд боловсруулах процессор - 1ш*147,449,741.2төг (Пролианс ХХК)<br>- Парафин цутгагч аппарат-1ш*55,435,078.2төг (Пролианс ХХК)<br>- Эргэлтэт микротом-1ш*62,295,551.9төг (Пролианс ХХК)<br>- Будагч автомат аппарат-1ш*219,459,493.3төг<br>- Эд эс хуулагч/grossing wells-1ш*44,578,666.7төг (Пролианс ХХК)<br>- Ухаалаг слайд дугаарлагч принтер-1ш*95,956,552.9төг (Медмонгол ХХК)<br>- Ухаалаг кассет дугаарлагч принтер-1ш*209,954,278.1төг (Медмонгол ХХК) | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | | | |
| 77 | 165 | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 | 5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 | Хамааралгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | | | |
| 107 | 207 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | 3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн (ХНУМТ) системд нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөдөлгөөний мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн оруулж Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр дамжуулан цалин хөлсийг олгож байна. http://ta.hrm.csc.gov.mn/ цахим системд албан хаагчдын анкет баталгаажуулах ажлыг 2025.10.24-28-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 69 ажилтны анкет баталгаажилт хийгдсэн. | 100% | |
| 112 | 213 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | ҮIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; (“Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. ) | Эмгэг судлалын үндэсний төвд 2025 онд сонсголын бэрхшээлтэй ажилтан 1 ажиллаж байна. Эрүүл мэндийн яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг бэлтгэн 2025.12.08-ны 422 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 214 | | ҮIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьялах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хамааралгүй. | | |
| 125 | 228 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33 | XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах. | | | |
| | 229 | | XIII.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав: 2.1. тархины саа, саажилт, уналт таталттай хүүхдийн уналт таталтын эсрэг эм хангамжийн нөхцөл байдлыг судалж, шаардлагатай эм, бэлдмэлийг бүртгэлжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх, төлбөрийг төрөөс хариуцах эмийн жагсаалтад оруулах, яаралтай горимоор хангах талаар холбогдох арга хэмжээ авах; 2.2. ховор тохиолддог өвчин, эмгэгийг эмчлэх болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нийлүүлэлт, нөөц, бэлэн байдлын асуудал хариуцсан байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулах эсэх асуудлыг судалж саналаа Засгийн газарт танилцуулах; 2.3. хүүхдийн өвчин, эмгэг, хавдар, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тархвар зүй, шалтгаан, хэрэгцээний талаар судалгаа хийж, өвчин, эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, эмчийн хандлага, харилцаа, эмийн болон бусад эмчилгээг олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2.4. бүх шатанд хүүхдийн мэдрэлийн эмгэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчилгээ, үйлчилгээний үр дүнг үнэлэх, нарийн мэргэжлийн эмчийг чадавхжуулах талаар зохих арга хэмжээ авах; 2.5. Монгол Улсад эмчлэх боломжгүй хүүхдийн өвчин, эмгэгийг гадаадын эмчилгээний багтай хамтран эх орондоо эмчлэх боломж, нөхцөлийг судалж, мэс засал яаралтай хийлгэх шаардлагатай зарим хүүхдийн асуудлыг 2022 оны 9 дүгээр сард багтаан нэн тэргүүнд шийдвэрлэх, эмчилгээний арга технологийг нутагшуулах замаар эмнэлгийн | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжилтнийг чадавхжуулах; 2.6. хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засахад шаардлагатай хүний нөөц, оношилгооны лаборатори, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах. | | | |
| | 230 | | XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | | |
| 126 | 231 | 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34 | XII.8.3. Улаанбаатар хотоос хөдөө рүү шилжин амьдрах асуудлыг дэмжих, орон нутагт амьдрахын давуу талыг сурталчлах, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг өрнүүлэх асуудлыг хамтран судалж, саналаа танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав. | Хамааралгүй. | | |
| 132 | 239 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | III.2. Иргэдэд хоол, хүнсний илчлэг (калори)-ийн талаар ойлголтыг олгож зохистой хэрэглээг бий болгох, эртэч, бүтээлч, эерэг, зөв хандлагатай эрүүл амьдралын хэмнэлийг бий болгох зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар хамтран шуурхай ажиллаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав. | | | |
| 133 | 240 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | 1/I-hospital программыг нэвтрүүлэн, цахим бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх ажил "Гүрэн Софт" ХХК-тай 2024.11.10-ны өдөр байгуулсан гэрээний үндсэн дээр цахим бүртгэлийн тогтолцоог ЭСҮТ 2025.01.25-ны өдрөөс нэвтрүүлж, хөгжүүлэлтийн ажил хийгдлээ.<br>2/ЭСҮТ-д цахим систем нэвтрүүлсэнтэй холбоотойгоор харилцагч эрүүл мэндийн байгууллагуудад партнер программын сургалтыг 2025.05.30-ны өдөр танхимаар, 2025.06.10-ны өдөр цахимаар зохион байгуулж, харилцагч эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангалаа.<br>3/Эмнэлгүүд дээр ашиглагдаж байгаа программ, манай төвд нэвтрүүлээд буй I-hospital программд хооронд интеграци хийлгэх тухай албан хүсэлтээ 2025.06.04-ний өдрийн 203 тоотоор ЭМЯ-ны Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтэст хүргүүллээ.<br>4/Эйблсофт ХХК-тай 2025.04.25-ны өдөр АҮШ-25/12 гэрээг байгуулж Able программыг 1,940,000 төгрөгөөр худалдан авч, өдөр тутмын албан хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглалаа.<br>5/ ЭСҮТ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа цахим систем болон мэдээллийн санг https://system.gov.mn/ цахим сайтад оруулан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны шинжээчээр баталгаажуулж, энэ талаарх мэдээллээ ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн албанд хүргүүлсэн. | 100% | |
| 136 | 246 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 | XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | | | |
| | 252 | | III.5. Авлигатай тэмцэх жилийн хүрээнд авлигыг таслан зогсоох, хүнд суртлыг арилгах чиглэлээр хариуцсан салбар бүрдээ тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Хамааралгүй. | | |
| 145 | 270 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | Хамааралгүй. | | |
| 148 | 274 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын | 1/Санхүүгийн ил тод байдал-12, Үйл ажиллагааны ил тод байдал-5, www.shilendans.gov.mn цахим системд 29 төрлийн 163, байгууллагын самбарт-10 удаа мэдээлэл боловсруулан байгууллагын цахим хуудсанд байршууллаа.<br>2/Байгууллагын цахим хуудаст санхүүгийн ил тод байдал цэсэд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2024 оны санхүүгийн аудитын тайлан, аудитын дүгнэлт, 2025 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ 22 удаа, ЭБАТ-ын 5 мэдээлэл, санхүүгийн ил тод байдлын 16 мэдээ, 2025 онд 561 удаагийн гүйлгээгээр 3,4 тэрбум төгрөгийн зардлын гүйлгээ гаргасан тухай мэдээллийг нийтэд ил тод нээлттэй мэдээлэн ажиллаа.<br>3/Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа ба 2025 оны 01-11 дүгээр саруудад төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ 22 удаа, өрийн мэдээг 12 удаа, хагас жилийн тайлан 1 удаа, мөн Үндэсний аудитын passaudit.gov.mn сайтад 2024 оны тайлан баланс санхүүгийн мэдээллийг бүрэн мэдээлсэн. . | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах. | 4/Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр 2025 оны 01-11 сарын байдлаар нийт 33 удаагийн (нийт гүйлгээний дүн 586,525,648 төгрөг)-ийн гүйлгээний мэдээллийг нийтэллээ. | | |
| | 291 | | 2.25. Эрүүл мэндийн даатгалаар олгогддог хөнгөлөлттэй эмийн чанарыг сайжруулах, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулан иргэдэд хүндрэлгүй байдлаар зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт; | Хамааралгүй. | | |
| | 302 | | XI.5.1. Аймаг, нийслэл, дүүрэг, сум дундын эмнэлэгт мэргэжлээс шалтгаалсан өвчний үзлэг хийх, сэргээн засах кабинет ажиллуулах, мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын шинэ эмнэлгийн үйл ажиллагааг 2024 оны 2 дугаар улиралд | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | багтаан эхлүүлэх талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт; | | | |
| | 303 | | XI.5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлын уялдаа холбоог сайжруулах, боловсрол, эрүүл мэнд, үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбаруудад тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ажилтныг стандартад нийцсэн ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслээр хангах үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав | Хамааралгүй. | | |
| | 333 | | 37.4.9. Нийслэл Улаанбаатар хотын агаарын чанарын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн үйлдвэрийн газруудын уурын зуухнуудад технологийн өөрчлөлт хийж, түүхий нүүрсний хэрэглээг бүрэн зогсоох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, | Хамааралгүй. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт; | | | |
| 174 | 341 | 2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай<br>2024-01-12<br>Дугаар 2024_01 | 7.15.Нэг эх үүсвэрээс эм худалдан авах, эмийн нэгдсэн худалдан авалтын хэлцлээр дамжуулан чанартай эмийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах) арга хэмжээг 2024 оны 1 дүгээр улиралд авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт; | ТХААГазрын ерөнхий гэрээнд эмнэлгийн 1 удаагийн хэрэгсэл багтсан байдаг тул цахим дэлгүүрээр дамжуулан худалдан авалтыг зохион байгуулж ажилладаг. 2025 онд нийт 37,311,500 төгрөгөөр эмнэлгийн 1 удаагийн хэрэгсэл худалдан авч лабораторийн үйл ажиллагаанд зарцуулсан. Үүнд:<br>-2025.05.16-ны өдрийн ЭСҮТ/020/001 дугаартай гэрээгээр 7,797,000 төгрөгийн 1 удаагийн халад 900ш, 1 удаагийн малгай 900ш, амны хаалт 900ш, улавч 300ш<br>-2025.10.03-ны өдөр ЭСҮТ/021/001 дугаартай гэрээгээр 9,592,500 төгрөгийн 1 удаагийн халад 1000ш, 1 удаагийн улавч 1000ш, 1 удаагийн амны хаалт 1300ш<br>-2025.10.09-ны өдөр ЭСҮТ/023/001 дугаартай гэрээгээр 250,000 төгрөгийн 1 удаагийн малгай 1000ш<br>-2025.12.19-ний ЭСҮТ/024/001 дугаартай гэрээгээр 572,000 төгрөгийн 1 удаагийн амны хаалт 2600ш<br>-2025.12.23-ны өдөр ЭСҮТ/025/001 дугаартай гэрээгээр 19,100,000 төгрөгийн 1 удаагийн халад 1 удаагийн улавч, 1 удаагийн малгайг тус бүр 2000ш | 100% | |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНЗОРИГ

ТАЙЛАНГ ГАРГАСАН:
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ДАРГА Б.ОТГОНГЭРЭЛ